



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2022 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 21

Улаанбаатар хот

Хөдөлмөрийн Үндэсний нам (ХҮН)-ын
дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт, мөрийн
хөтөлбөрийн шинэчилсэн найруулгыг улсын
бүртгэлд бүртгүүлэх, намын улсын
бүртгэлийн гэрчилгээг дахин авах
өргөдлийн тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Ч.Тунгалаг, Ч.Хосбаяр, шүүгч Б.Амарбаясгалан, Г.Банзрагч, М.Батсуурь, С.Батдэлгэр, Х.Батсүрэн, Б.Батцэрэн, П.Золзаяа, Б.Мөнхтуяа, С.Соёмбо-Эрдэнэ, П.Соёл-Эрдэнэ, Б.Цогт, Д.Эрдэнэбалсүрэн, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

“Хөдөлмөрийн Үндэсний намын дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт, мөрийн хөтөлбөрийн шинэчилсэн найруулгыг улсын бүртгэлд бүртгүүлэх”, “намын улсын бүртгэлийн гэрчилгээг дахин авах” тухай өргөдлийг шүүгч Х.Батсүрэнгийн танилцуулснаар хянан хэлэлцээд ТОДОРХОЙЛОХ нь:

Нэг.Хөдөлмөрийн Үндэсний намын дарга Т.Доржхандын 2022 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 10/22 дугаар албан бичгээр тус шүүхэд ирүүлсэн өргөдөлдөө: Хөдөлмөрийн Үндэсний намын ээлжит бус 7 дугаар Их хурал 2022 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр хуралдаж намын мөрийн хөтөлбөрийг шинэчлэн батлах, намын бүтэн нэрийг “ХҮН нам”, товчилсон нэрийг “ХҮН” болгон өөрчлөх, намын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг батлах зэрэг шийдвэрүүдийг гаргасан болно. Намын үүсгэн байгуулсан баримт бичигт оруулсан өөрчлөлтийн мэдээллийг Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2021 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 09 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Улс төрийн намын бүртгэл хөтлөх журмын хавсралт №2А маягтын дагуу гаргаж хүргүүлэв. ХҮН намын үүсгэн байгуулсан баримт бичигт оруулсан өөрчлөлтийг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу улсын бүртгэлд бүртгэж өгнө үү” гэсэн өргөдөл гаргаж, өргөдөлдөө:

-Хөдөлмөрийн Үндэсний намын Төлөөлөх зөвлөлийн хурлын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн “Хурлын хэлэлцэх асуудлыг батлах тухай” 04 дүгээр тогтоол,

-“Намын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг дэмжих тухай” 05 дугаар тогтоол (тус тогтоолын хавсралтаар “Дүрмийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлал”-ын төсөл)

-Хөдөлмөрийн Үндэсний намын ээлжит бус 7 дугаар Их хурлын 2022 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн дараах тогтоолууд:

- “Хуралдааны тэргүүлэгчдийг батлах тухай” 01 дүгээр тогтоол,
- “Тооллогын комиссын бүрэлдэхүүн батлах тухай” 02 дугаар тогтоол,

- “Редакцын комиссын бүрэлдэхүүн батлах тухай” 03 дугаар тогтоол,
- “Ээлжит бус 7 дугаар Их хурлын хэлэлцэх асуудал батлах тухай” 04 дүгээр тогтоол, хавсралт
- “Хуралдааны дэгийг батлах тухай” 05 дугаар тогтоол,
- Ээлжит бус 7 дугаар Их хурлын хуралдааны дэг,
- “Намын мөрийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” 06 дугаар тогтоол,
- “Намын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг батлах тухай” 07 дугаар тогтоол,
- Хөдөлмөрийн Үндэсний намын ээлжит бус 7 дугаар Их хурлын оролцогчдын бүртгэл,
- Хөдөлмөрийн Үндэсний намын ээлжит бус 7 дугаар Их хурлын хуралдааны тэмдэглэл,
- Хөдөлмөрийн Үндэсний намын Удирдах зөвлөлийн хурлын 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн “Намын ээлжит бус 7 дугаар Их хурлыг хуралдуулах тухай” 04/22 дугаар тогтоол,
- Намын хороодуудын “Ээлжит бус 7 дугаар Их хуралд төлөөлөгч оролцуулах тухай” тогтоолууд,
- Хөдөлмөрийн Үндэсний намын Удирдах зөвлөлийн хурлын 2022 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” 03/22 дугаар тогтоол,
- Намын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийн төслийн танилцуулга болон саналыг олон нийтэд зарласантай холбоотой материалууд,
- Улсын бүртгэлийн гэрчилгээний эх хувь,
- Улсын тэмдэгтийн хураамжид 150,000 төгрөг төлсөн баримтуудыг хавсарган ирүүлсэн байна.

Хоёр. “ХҮН нам нь 2022 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн намын ээлжит бус 7 дугаар Их хурлаар намын оноосон нэр, намын мөрийн хөтөлбөрийг өөрчилж, намын дүрмийг нэмэлт, өөрчлөлт оруулан баталсан бөгөөд Улс төрийн намын тухай хуульд заасны дагуу өөрчлөлтийг бүртгүүлэхээр холбогдох бичиг баримтын бүрдлийг ханган хүргүүлж байна. Намын оноосон нэр өөрчлөгдсөнтэй холбогдуулан намын улсын бүртгэлийн гэрчилгээг дахин авах хүсэлтээ үүгээр илэрхийлж байгаа тул Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.8.3 дахь хэсэгт заасны дагуу гэрчилгээг дахин олгож өгнө үү” гэжээ.

ҮНДЭСЛЭХ нь:

Хөдөлмөрийн Үндэсний намын дарга Т.Доржхандаас “намын дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт, мөрийн хөтөлбөрийн шинэчилсэн найруулгыг улсын бүртгэлд бүртгүүлэх”, “намын улсын бүртгэлийн гэрчилгээг дахин авах” тухай өргөдлийг 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдөр ирүүлсэн нь Улс төрийн намын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т нийцсэн байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5, 4.1.6, 10 дугаар зүйлийн 10.1.6, 10.1.8-д тус тус зааснаар намын дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт, мөрийн хөтөлбөрийн шинэчилсэн найруулга нь улс төрийн намын улсын бүртгэл, хуулийн этгээдийн хувийн хэргийн агуулгад заавал тусгах мэдээлэлд хамаарах бөгөөд дээрх өргөдлийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6, 15 дугаар зүйлийн 15.1-т заасны дагуу Монгол Улсын Үндсэн хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Улс төрийн намын тухай хууль болон тус намын дүрэмд нийцсэн эсэхийг хянах замаар шийдвэрлэнэ.

Хөдөлмөрийн Үндэсний намын Удирдах зөвлөлийн хурлын 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 04/22 дугаар тогтоолоор намын ээлжит бус 7 дугаар Их хурлаа 2022 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр Монголын Үндэсний Худалдаа Аж үйлдвэрийн Танхимын Их танхимд зарлан хуралдуулсан нь тус намын дүрмийн 4.7-д “Намын

дарга намын ээлжит бус Их хурлыг хуралдуулах саналыг Удирдах зөвлөлд оруулж болох бөгөөд саналыг Удирдах зөвлөл 14 хоногийн дотор хэлэлцэж ээлжит бус Их хурал хуралдуулах шийдвэр гаргана” гэж заасантай нийцжээ.

Улс төрийн намын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.5 -д “намын дүрмээр, намын Их хурлын төлөөлөгч сонсох журмыг зохицуулна” гэж заасан, өргөдөлд тус намын хороодуудын “Ээлжит бус 7 дугаар Их хуралд төлөөлөгч оролцуулах тухай” тогтоолуудыг хавсарган ирүүлснээс үзвэл, 2022 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн Их хуралд намын аймаг, нийслэлийн нэгжээс нийт 147 гишүүдийг төлөөлөгчөөр оролцуулахаар сонгож батламжилсан нь тус намын дүрмийн 4.3-т “Намын анхан болон дунд шатны нэгжээс дараах тооны гишүүдийг их хурлын төлөөлөгчөөр сонгоно. -нийслэлийн намын хорооноос 9 төлөөлөгч, -Аймаг, дүүргийн намын хорооноос тус бүр 1 төлөөлөгч, -Намын анхан шатны байгууллагаас тус бүр 1 төлөөлөгч” гэж заасанд нийцжээ.

Түүнчлэн Их хуралд танхимаар 97, цахимаар 16, нийт 113 төлөөлөгч оролцсоныг нийт төлөөлөгчдийн олонхи оролцсон гэж үзэх тул Улс төрийн намын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т “Нам үйл ажиллагаандаа дараахь нийтлэг зарчмыг баримтална: 5.1.4-т “дотоод асуудлаа ардчилсан зарчмыг баримтлан олонхын саналаар шийдвэрлэх”, 14 дүгээр зүйлийн 14.1-т “Нам дор дурдсан эрхтэй байна: 14.1.4-т “хуульд өөрөөр заагаагүй бол үйл ажиллагааныхаа зохион байгуулалтын бүтэц, зорилт, арга хэлбэрээ чөлөөтэй сонгох” гэсэн зохицуулалт болон тус намын дүрмийн 4.8-д “Намын Их хурлыг нийт төлөөлөгчдийн олонхи нь оролцсоноор хүчинтэйд тооцно” гэж зааснаар ээлжит бус 7 дугаар Их хурлыг хүчинтэйд тооцов.

Улс төрийн намын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Намын удирдах дээд байгууллага нь намын Их Хурал байна”, 13.2-т “Дараахь асуудлыг зөвхөн намын Их Хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ”; 13.2.1-д “намын дүрэм, мөрийн хөтөлбөрийг батлах”, Хөдөлмөрийн Үндэсний намын дүрмийн 4.9-т “Намын Их хурал нь дараах онцгой бүрэн эрхтэй: 4.9.1-т “Намын дүрэм, мөрийн хөтөлбөрийг батлах, тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулах”, 4.9.6-д “Намыг өөрчлөн байгуулах, үйл ажиллагааг зогсоох, нэрийг өөрчлөх” бүрэн эрхийг тус намын Их хуралд олгосон байгаа тул намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, мөрийн хөтөлбөрийг шинэчлэн найруулах болон намын нэрийг өөрчлөх асуудал нь Хөдөлмөрийн Үндэсний намын Их хурлын эрх хэмжээнд хамаарч байна.

Хөдөлмөрийн Үндэсний намаас ирүүлсэн өргөдөлд, тус намын 2022 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит бус 7 дугаар Их хурлын 04 дүгээр тогтоолоор “намын дүрмийн нэмэлт, өөрчлөлт”, “намын үзэл баримтлалыг батлах (мөрийн хөтөлбөрийг шинэчлэх)” асуудлыг тус тус хэлэлцэхээр баталж, ээлжит бус 7 дугаар Их хурлын 06 дугаар тогтоолоор намын мөрийн хөтөлбөрийг шинэчлэн баталсныг, 07 дугаар тогтоолоор намын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг баталсныг тус тус улсын бүртгэлд бүртгүүлэхээр ирүүлжээ.

Нэг.Намын мөрийн хөтөлбөрийг шинэчлэн найруулсан тухайд

Хөдөлмөрийн Үндэсний намын ээлжит бус 7 дугаар Их хурлын төлөөлөгчдийн 93.8 хувийн саналаар Их хурлын “Намын мөрийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” 06 дугаар тогтоолын хавсралтаар намын мөрийн хөтөлбөрийг шинэчлэн баталж, “... эрхэм зорилго, үйл ажиллагааны зарчим, намын үзэл баримтлал, (хүмүүнлэг эрх чөлөөний үзлийн суурь таван зарчим), мөрийн хөтөлбөр (хөгжлийн зорилт, хөгжлийн тулгуур стратеги, мөрийн хөтөлбөрийн үндсэн чиглэл)” гэсэн

бүтэцтэйгээр, үзэл баримтлалыг “...Хүмүүнлэг эрх чөлөөний үзэл санаанд үндэслэсэн, баруун төвийн үзэл баримтлал” гэж шинэчлэн найруулан тодорхойлжээ.

Хоёр. Намын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийн тухайд

Монгол Улсын дээд шүүхийн хуралдааны 2018 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 13 дугаар тогтоолоор¹ бүртгэгдсэн Хөдөлмөрийн Үндэсний намын дүрэм нь тус намын 2018 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн ээлжит бус Их хурлаар батлагдсан 12 бүлэг, 93 хэсэг, 73 заалт, 4 дэд заалттай байна. Намын дүрэмд дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулахаар ээлжит бус 7 дугаар Их хурлаар хэлэлцэж, хурлын төлөөлөгчдийн 98.2 хувийн саналаар Их хурлын “Намын дүрмийн нэмэлт, өөрчлөлт батлах тухай” 07 дугаар тогтоолын хавсралтаар баталсан нь хурлын тэмдэглэлд тусгагджээ. Үүнд:

2.1. Нэгдүгээр бүлэгт оруулсан нэмэлт, өөрчлөлтийн талаар

Намын дүрмийн 1.1, 1.2-ийг “1.1. ХҮН нам (цаашид “Нам” гэх) нь Хөдөлмөрийн Үндэсний намын хууль ёсны эрх залгамжлагч мөн бөгөөд гишүүдийн сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдсэн, улс төрийн үйл ажиллагааг хараат бус, бие даасан байдлаар явуулдаг Монгол Улсын иргэдийн нэгдэл мөн. ХҮН нам нь Монгол Улсаа 21-р зууны хөгжлийн шинэ эринд гаргах их үйлсийг түүчээлэх, эх орондоо хүмүүнлэг, иргэний, ардчилсан, аз жаргалтай, эрх чөлөөт нийгмийг байгуулах эрхэм зорилготой, Хүмүүнлэг эрх чөлөөний үзэл баримтлал бүхий баруун төвийн нам байна.”; “1.2. ХҮН нам нь байгальд ойр, эрх чөлөөт Монголын язгуур үнэт зүйлд тулгуурласан, үндэсний эрх ашиг, эв нэгдэл, хүний эрхэм чанар, эрх чөлөө, хувийн өмч, хүний хөгжил, тэгш боломж, бизнес хийх, хөдөлмөрлөх, бүтээх, эрх чөлөөг эрхэмлэн дээдэлсэн Хүмүүнлэг эрх чөлөөний үзэл-ийг баримтална.” гэж өөрчлөн шинэчилсэн,

“1.3. Хөдөлмөрийн Үндэсний нам нь хүнээ дээдэлсэн Монгол Улсын хөгжлийн бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэгтэй” гэх заалтыг хүчингүй болсонд тооцсон,

“1.4.2. Үндэсний ашиг сонирхлыг намын, бүлгийн, хувийн ашиг сонирхлоос ямагт дээдлэн эрхэмлэх;” гэх заалтын “Үндэсний” гэдгийн араас “язгуур” гэж нэмсэн,

“1.5. “Намын бүтэн нэр” ХҮН нам”, товчилсон нэр “ХҮН”, англи хэлээр “The HUN Party” байна. Намын төв байгууллага нь Монгол Улсын нийслэлд байрлана.”;

“1.6. Нам нь өөрийн бэлгэдэл, далбаатай байна. Намын бэлгэдэл ХҮН лого нь Монгол Улсын эрхэм дээд баялаг, эх орны эзэн, хөгжил дэвшлийг бүтээгч нь Монгол хүн гэдгийг илэрхийлнэ. Баруун тийш хандсан сумны зэв нь ХҮН нам Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний язгуур эрх ашгийг ямагт эрхэмлэн, эх орноо дэлхийн Монгол болгон хөгжүүлэхийн төлөө зэв мэт хурц, тууштай зүтгэхийг, намын бодлого нь хүнд чиглэж, хүний эрх, эрх чөлөө, тэр дундаа баялаг бүтээх эрх чөлөөг онцлон дээдэлсэн оновчтой шийдэл, хөгжлийн гарц буюу Хүмүүнлэг эрх чөлөөний үзэл баримтлалыг илэрхийлнэ. Намын бэлгэдлийн өнгө нь цэвэр тунгалаг, шинэ эрч хүч, тэгш боломжийг бэлгэдсэн яргуй цэцгийн нил ягаан болон цэвэр ариун, шударга үнэн байдлын илэрхийлэл сүүн цагаан өнгөний хослол байна.” гэж тус тус өөрчлөн шинэчилсэн;

2.2. Хоёрдугаар бүлэгт оруулсан нэмэлт, өөрчлөлтийн талаар

Намын дүрмийн “2.1. Намын үзэл баримтлал, зарчим, мөрийн хөтөлбөр, дүрэм, үйл ажиллагааг хүлээн зөвшөөрч, эвлэлдэн нэгдэхээ илэрхийлсэн 18 нас хүрсэн

¹ Хөдөлмөрийн Үндэсний намын хувийн хэргийн 4-р хавтас 664-666х

Монгол Улсын иргэн намд гишүүнээр элсэж болно.” гэх заалтын “Намын” гэдгийн ард “эрхэм зорилго,” гэж,

“2.2.Намын, үзэл баримтлал, зарчим, мөрийн хөтөлбөрийг дэмжиж буй иргэн намын гишүүнээр элсэхгүйгээр бүртгүүлж болно. Бүртгэлийг намын анхан шатны байгууллага хөтлөнө.” гэх заалтад “Намын” гэсний ард “эрхэм зорилго,” “элсэхгүйгээр” гэсний ард “дэмжигч гишүүнээр”, “болно.” гэсний ард “Дэмжигч гишүүний” гэж,

“2.3.Намд гишүүнээр элсэх иргэн хүсэлтээ оршин суугаа газарт үйл ажиллагаа явуулдаг намын анхан шатны байгууллагад тогтоосон маягтын дагуу бичгээр гаргах бөгөөд хүсэлтийг тухайн анхан шатны байгууллагын тэргүүлэгчдийн хурлаар шийдвэрлэж, гишүүнээр бүртгэн намын гишүүний батламжийг олгоно” гэх заалтын “хүсэлтээ” гэсний ард “өөрийн”, “бичгээр” гэсний ард “эсвэл цахим хэлбэрээр” гэж,

“2.4.Намын анхан шатны байгууллагын дарга нь хагас жил тутамд, шаардлагатай тохиолдолд тухай бүр гишүүдийн бүртгэлийн өөрчлөлтийн талаарх мэдээллийг ажлын албаны гишүүнчлэлийн асуудал хариуцсан нэгжид хүргүүлнэ” гэх заалтад “мэдээллийг” гэсний ард “Гүйцэтгэх зөвлөлийн” гэж,

“2.7.Иргэний намыг гишүүнээр элсүүлэхээр энэхүү дүрмийн 2.3-т заасан намын анхан шатны байгууллагын шийдвэрийн талаар гишүүд үндэслэл бүхий эсэргүүцэл гаргаж болох бөгөөд энэхүү эсэргүүцлийг намын хяналтын байгууллага эцэслэн шийдвэрлэнэ” гэх заалтад “2.3-т заасан” гэснийг “2.-т заасны дагуу гаргасан” гэж өөрчлөн, “шийдвэрийн талаар” гэсний ард “намын” гэж тус тус нэмсэн,

2.3.Гуравдугаар бүлэгт оруулсан нэмэлт, өөрчлөлтийн талаар

Намын дүрмийн “3.1.Сум, хороо дахь намын үүр нь намын анхан шатны байгууллага байна. Орон нутгийн баг болон нийслэлийн хорооны хэсэгт намын төлөөлөгчийг эсвэл хэсгийг ажиллуулж болно.” гэх заалтын “намын үүр” гэснийг “намын үүрийн тэргүүлэгчид” гэж өөрчлөн,

“3.2.Аймаг, нийслэл, дүүргийн намын хороо нь намын дунд шатны байгууллага байна.” гэх заалтын “намын хороо” гэснийг “намын хорооны тэргүүлэгчдийн” гэж өөрчлөн,

“3.3.Намын анхан болон дунд шатны байгууллагыг намын Удирдах зөвлөлийн шийдвэрийн дагуу эмхлэн байгуулах бөгөөд дарга, тэргүүлэгчдийг тухайн шатны намын гишүүдийн олонхын саналаар, нууц санал хураалтаар сонгож байгуулна. Нийслэлийн намын хорооны тэргүүлэгчдийн хурал нь дарга болон 9 хүртэл тооны тэргүүлэгчдээс, аймаг, дүүргийн намын хорооны тэргүүлэгчдийн хурал нь дарга болон 4-өөс цөөнгүй бөгөөд 8-аас ихгүй тооны тэргүүлэгчдээс, сум, хорооны намын үүргийн тэргүүлэгчдийн хурал нь дарга болон 4 хүртэл тооны тэргүүлэгчдээс бүрдэнэ. Тухайн сум, хороонд намын анхан шатны байгууллагыг байгуулаагүй бол харьяалах дээд шатны намын байгууллага нь энэхүү дүрэмд заагдсан намын анхан шатны байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлнэ.” гэх заалтыг нэмж өөрчилсөн;

2.4.Дөрөвдүгээр бүлэгт оруулсан нэмэлт, өөрчлөлтийн талаар

Намын дүрмийн 4.2-т “Дараах сонгууль албан тушаалтнууд нь намын их хурлын төлөөлөгчид байна.” гээд “-Удирдах зөвлөлийн дарга, гишүүн” гэснээс “дарга”-г хасаж, “-Засгийн газрын гишүүн” гэдгийг “Монгол Улсын Засгийн Газрын гишүүн” гэж өөрчлөн, “-Төлөөлөх зөвлөлийн гишүүн” гэж нэмсэн,

“4.3.-Нийслэлийн намын хорооноос 9 төлөөлөгч; -Аймаг, дүүргийн намын хорооноос тус бүр 4 төлөөлөгч” гэснийг “Нийслэлийн намын хорооны

тэргүүлэгчдийн хурлаас 9 төлөөлөгч; -Аймаг, дүүргийн намын хорооны тэргүүлэгчдийн хурлаас тус бүр 4 төлөөлөгч” гэж өөрчлөн,

“4.5.Намын ээлжит Их хурлыг УИХ-ын сонгуулийн өмнөх жил болон сонгуулийн дараа тухайн жилд багтаан хуралдуулна. Их хурлыг хуралдуулах шийдвэрийг 30-аас доошгүй хоногийн өмнө намын Удирдах зөвлөлөөс гаргана.” гэх заалтыг “Намын ээлжит Их хурлыг 4 жилд 1 удаа хуралдуулна. Их хурлыг хуралдуулах шийдвэрийг 30-аас доошгүй хоногийн өмнө намын Удирдах зөвлөлөөс гаргана” гэж өөрчлөн,

“4.6.Намын төлөөллийн төв байгууллагын нийт гишүүдийн гуравны хоёр, эсвэл намын Их хурлын нийт төлөөлөгчдийн гуравны нэгийн шаардсанаар намын ээлжит бус Их хурлыг Удирдах зөвлөлөөс зарлан хуралдуулж болно” гэх заалтын “гуравны нэгийн” гэдгийг “гуравны нэгээс доошгүй хувийн” гэж өөрчлөн,

“4.9.3.Намын хариуцлагын ерөнхий хорооны гишүүдийг сонгох, тэдгээрийн тайланг хэлэлцэх;” гэх заалтын сонгох” гэсний ард “чөлөөлөх” гэж нэмсэн,

“4.9.4.Намын дарга, Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, Ерөнхий нарийн бичгийн даргыг сонгох, чөлөөлөх;” гэх заалтаас “Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, Ерөнхий нарийн бичгийн дарга” гэснийг хассан,

“4.9.5.Намын даргыг сонгох, чөлөөлөх саналыг Намын Төлөөлөх зөвлөлийн хурал, Удирдах зөвлөлийн даргыг сонгох, чөлөөлөх саналыг Намын дарга, Ерөнхий нарийн бичгийн дарга болон Удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, чөлөөлөх саналыг Удирдах зөвлөлийн дарга тус тус гаргана.” гэх заалтыг хүчингүй болсонд тооцсон;

2.5.Тавдугаар бүлэгт оруулсан нэмэлт, өөрчлөлтийн талаар

“5.2.Төлөөлөх зөвлөлийн бүрэлдэхүүнд албан тушаалын зарчмаар дараах намын гишүүд орно.” гэх заалтад “-Намын Ерөнхий нарийн бичгийн дарга” гэж нэмж, “-Засгийн газрын гишүүн;” гэснийг “Монгол Улсын Засгийн газрын гишүүн;” гэж,

“5.3.Сонгуулийн зарчмаар сонгогдох Төлөөлөх зөвлөлийн төлөөлөгчдийг аймаг, нийслэл, дүүргийн намын хороод болон намын гүйцэтгэх төв байгууллага сонгоно. ...” гэх заалтын “аймаг, нийслэл, дүүргийн намын хороод” гэснийг “хорооны эрх барих байгууллага” гэж,

“5.4.Албан тушаалын зарчмаар тухайн Төлөөлөх зөвлөлийн бүрэлдэхүүнд орсон гишүүн тухайн албан тушаалаасаа чөлөөлөгдсөн тохиолдолд тэднийг чөлөөлж, тэдгээрийн оронд тухайн албан тушаалд сонгогдсон эсвэл томилогдсон намын гишүүнийг Гүйцэтгэх зөвлөл баталгаажуулж намын Төлөөлөх зөвлөлийн гишүүнээр бүртгэнэ. Сонгуулийн зарчмаар сонгогдсон гишүүний сул орон тоо гарвал тухайн гишүүнийг сонгосон намын байгууллага намын гишүүдээс нэр дэвшүүлж нөхөн сонгож Гүйцэтгэх зөвлөлд хүргүүлж бүртгэлд хамруулна” гэж,

“5.6.Удирдах зөвлөлийн гишүүд нь Намын Төлөөлөх зөвлөлийн хурлын тэргүүлэгчид байх бөгөөд намын Төлөөлөх зөвлөлийн хуралдааныг Удирдах зөвлөлийн дарга даргална.” гэх заалтыг “Намын Төлөөлөх зөвлөлийн хуралдааныг намын дарга даргална” гэж,

“5.8.4.Намын Ерөнхий нарийн бичгийн даргын санал болгосноор намын нарийн бичгийн даргыг томилох;” гэх заалтыг “Ерөнхий нарийн бичгийн дарга болон намын даргаас бусад Удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, чөлөөлөх;” гэж тус тус өөрчлөн,

“5.8.9.Намын Төлөөлөх зөвлөл нь дараах журмуудыг батлан мөрдүүлнэ.” гэх заалтад “5.8.9.4.Намын гишүүнчлэлийн журам, 5.8.9.5.Намын дотоод сонгуулийн журам, 5.8.9.6.Намын санхүүгийн журам хамаарна” гэх заалтуудыг нэмсэн,

“5.9.Удирдах зөвлөл нь нийт 5 гишүүнээс бүрдэх ба бүрэлдэхүүнд нь Намын дарга, Удирдах зөвлөлийн дарга, Ерөнхий нарийн бичгийн дарга болон Удирдах зөвлөлийн 2 гишүүн багтана.” гэх заалтын “5” гэснийг “25 хүртэл”, “Удирдах зөвлөлийн дарга,” гэснийг хасаж, “2” гэснийг “23 хүртэл” гэж,

“5.10.Удирдах зөвлөлийн даргыг Намын даргын санал оруулснаар, Ерөнхий нарийн бичгийн дарга, Удирдах зөвлөлийн 2 гишүүнийг Удирдах зөвлөлийн даргын санал оруулснаар Намын их хурлаас тус тус сонгоно.” гэж заасныг “Дүрмийн 5.8.4-д заасан Ерөнхий нарийн бичгийн дарга болон Удирдах зөвлөлийн 23 гишүүнийг сонгуулахаар Намын дарга Төлөөлөх зөвлөлд нэр дэвшүүлэн санал оруулна.” гэж,

“5.11.Удирдах зөвлөл нь дараах бүрэн эрхтэй: 5.11.1.Намын Төлөөлөх зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлыг бэлдэх, зохион байгуулах,” гэх заалтын “бэлдэх, зохион байгуулах,” гэснийг “хэлэлцэж санал, дүгнэлт гаргаж, Төлөөлөх зөвлөлийн хуралд танилцуулах,” гэж тус тус өөрчилсөн,

“5.11.3.Бүх шатны сонгуульд Намаас нэр дэвшигчдийг тодруулахад дэмжлэг үзүүлэх үндсэн чиг үүрэг бүхий Сонгуулийн зөвлөлийг зохион байгуулан ажиллуулж болох ба хэрэв Сонгуулийн зөвлөл байгуулсан тохиолдолд тус зөвлөлийг сонгуулийн жилийн эхээр байгуулж тухайн жилдээ багтаан татан буулгана.” гэх заалтыг хүчингүйд тооцсон,

“5.11.4.Төлөөлөх зөвлөлийн чөлөөт цагт 5.8.9-д заасан журмуудад нэмэлт өөрчлөлт оруулах, улс төрийн шийдвэр гаргах”, 5.11.5.Намын дэд даргыг намын даргын санал болгосноор томилох, 5.12.Тодорхой асуудлыг шийдэх зорилгоор намын Удирдах зөвлөлийн шийдвэрээр ажлын хэсэг байгуулан ажиллуулж болно. Ажлын хэсэг нь намын Удирдах зөвлөлөөс баталсан шийдвэр, удирдамж, зарчмаар ажиллах ба намын бүх шатны байгууллагын гишүүд болон намын гишүүн бус иргэдийг ажлын хэсэгт оролцуулан ажиллуулж болно.” гэх заалтуудыг нэмсэн;

2.6.Зургаадугаар бүлэгт оруулсан нэмэлт, өөрчлөлтийн талаар

Намын дүрмийн “6.1.Хөдөлмөрийн Үндэсний Нам даргатай байх ба Намын дарга нь намын тэргүүн мөн” гэж заасныг “ХҮН нам даргатай байх ба Намын дарга нь намын тэргүүн мөн. Нам нь 3 хүртэл тооны дэд даргатай байж болно.” гэж,

“6.2.2.Удирдах зөвлөлийн даргыг сонгох, чөлөөлөх саналыг намын Их хуралд оруулах; 6.2.3.Намын дүрэм, мөрийн хөтөлбөр, намын Их хурал, намын Төлөөлөх зөвлөлийн шийдвэрийг хэрэгжүүлэх, намын хүний нөөцийн бодлоготой холбоотой асуудлаар Удирдах зөвлөлд санал оруулах; 6.2.4.УИХ-ын сонгуульд намыг удирдаж ялуулсан Намын дарга Ерөнхий сайд байна. ...,” гэх заалтуудыг “6.2.2.Намын Ерөнхий нарийн бичгийн дарга болон Удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, чөлөөлөх саналыг намын Төлөөлөх зөвлөлийн хуралд оруулах, 6.2.3.Намын дүрэм, журам, сонгуулийн мөрийн хөтөлбөр болон намын Их хурал, намын Төлөөлөх зөвлөлийн шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор намын Ерөнхий нарийн бичгийн даргад үүрэг, даалгавар, чиглэл өгөх, 6.2.4.УИХ-ын сонгуульд нам олонх болсон тохиолдолд тухайн сонгуульд намыг удирдаж ялуулсан Намын дарга Ерөнхий сайдад нэр дэвшинэ. ...,” гэж,

“6.3.Намын дарга хүндэтгэн үзэх шалтгаанаар албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд түүнийг шинээр сонгох хүртэл бүрэн эрхийг нь намын

Удирдах зөвлөлийн дарга хэрэгжүүлнэ.” гэх заалтын “Удирдах зөвлөлийн дарга” гэснийг “Ерөнхий нарийн бичгийн дарга” гэж,

“6.4.Намын даргын дэргэд намын бодлого, үйл ажиллагааны уламжлалыг хангах үүднээс улс төрийн бодлогын талаар зөвлөлдөх байнгын бус зөвлөхүүдийн танхим ажиллана. Танхим нь намын дарга, намын ерөнхий нарийн бичгийн даргаар ажиллаж байсан намын гишүүд, Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүн, Ерөнхий сайд зэрэг төрийн дээд албан тушаал хашиж байсан туршлагатай хүмүүсээс бүрдэнэ.” гэх заалтын “зөвлөхүүдийн танхим” гэснийг “бодлогын зөвлөл” гэж, “Танхим” гэснийг “Зөвлөл” гэж, “намын ерөнхий нарийн бичгийн даргаар ажиллаж байсан намын гишүүд” гэсний ард “болон намын даргын урилгаар” гэж тус тус нэмсэн;

2.7.Долоодугаар бүлэгт оруулсан нэмэлт, өөрчлөлтийн талаар

Намын дүрмийн “7.2.Гүйцэтгэх зөвлөл нь Ерөнхий нарийн бичгийн даргыг оролцуулан 5 хүний бүрэлдэхүүнтэй байна. Гүйцэтгэх зөвлөлийн бүрэлдэхүүнийг Ерөнхий нарийн бичгийн даргын санал оруулснаар намын Төлөөлөх зөвлөлөөс томилно.” гэх заалтын “даргыг” гэснийг “дарга болон 4 нарийн бичгийн даргаас бүрдэнэ. Нарийн бичгийн дарга нарыг” гэж,

“7.3.Намын Гүйцэтгэх зөвлөлийн бүрэлдэхүүний гуравны хоёроос илүүгүй нь УИХ-ын болон Засгийн газрын гишүүд байж болно.” гэх заалтыг хүчингүйд тооцсон,

“7.5” гэсэн дугаарыг “7.4”, “7.6” гэснийг “7.5” гэж,

“7.6.1.Намын бүх шатны байгууллагын үйл ажиллагааны нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах;” гэх заалтын дугаарыг “7.5.1.”, “бүх шатны” гэдгийг “анхан болон дунд шатны” гэж, “хангаж” гэсний дараа “,чиглэл өгч” гэж,

“7.6.4.Намын аж ахуй, санхүүгийн байдлын талаар намын Төлөөлөх зөвлөлд тайлагнахын хамт намын Хариуцлагын ерөнхий хороонд тухай бүр мэдээлж байх;” гэх заалтын дугаарыг “7.5.4”, “тухай” гэснийг “жил” гэж,

“7.6.5.Намын хүний нөөцийг бодлогыг хэрэгжүүлэх;” гэх заалтын дугаарыг “7.5.5”, “Намын дотоод болон бүх шатны төрийн сонгуульд нэр дэвших хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх;” гэж тус тус өөрчилсөн,

“7.6.6.Намын татвар, хураамжийг тогтоох, санхүүжилтийн журмыг батлах;” гэснийг хассан,

“7.6.7” гэсэн дугаарыг “7.5.6” гэж,

7.6.8.Намын гишүүдийн сахилга, ёс зүйн байдлын талаар аймаг, нийслэл, дүүргийн Хариуцлагын хорооны мэдээллийг хагас жил тутам сонсон намын холбогдох байгууллага, албан тушаалтанд зохих үүрэг даалгавар өгөх,” гэх заалтын дугаарыг “7.5.7”, “аймаг, нийслэл, дүүргийн” гэснийг “бүх шатны” гэж тус тус өөрчлөн,

“7.6.9” дахь заалтыг хүчингүйд тооцсон,

“7.6.10.Намын Төлөөлөх зөвлөлөөс шилжүүлсэн буюу даалгасан бусад эрх, үүрэг.” гэх заалтыг “Намын Төлөөлөх зөвлөлөөс шилжүүлсэн, олгосон болон ногдуулсан бусад эрх, үүрэг.” гэж,

“7.7.Гүйцэтгэх зөвлөлийн гишүүдийн олонхи нь оролцсоноор хуралдааны ирцийг хүчинтэйд тооцно.” гэх заалтын дугаарыг “7.6” гэж тус тус өөрчилсөн,

“7.8” дахь заалтыг хүчингүйд тооцсон,

“7.9.Гүйцэтгэх зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж буй асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэж тогтоол гаргана.” гэх заалтыг “7.7.Гүйцэтгэх зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж шийдсэн асуудлаар намын Ерөнхий нарийн бичгийн дарга тушаал, шийдвэр гаргана.” гэж өөрчилсөн,

“7.10.Шаардлагатай тохиолдолд Гүйцэтгэх зөвлөлийн хуралдааныг өргөтгөсөн бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулж болно.” гэх заалтыг хүчингүйд тооцсон,

“7.11” дэх заалтын дугаарыг “7.8” гэж өөрчилсөн,

“7.12.Гүйцэтгэх зөвлөл нь намын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий ажлын албатай байна.” гэх заалтын дугаарыг “7.9” гэж, уг заалтаас “бодлого боловсруулах, хэрэгжүүлэх” гэснийг хассан,

“7.13.Ажлын албаны дүрэм, зохион байгуулалтын бүтэц, орон тоо, төсвийг Гүйцэтгэх зөвлөл батална. Гүйцэтгэх зөвлөлийн ажлын албаны нэгжийн удирдлага, ажилтныг томилохдоо сонгон шалгаруулах зарчмыг баримтална.” гэх заалтыг “7.10.Гүйцэтгэх зөвлөлийн зохион байгуулалтын бүтэц, орон тоо, төсвийг Гүйцэтгэх зөвлөл батална. Гүйцэтгэх зөвлөлийн ажлын албаны нэгжийн удирдлага, ажилтныг томилохдоо сонгон шалгаруулах зарчмыг баримталж, Ерөнхий нарийн бичгийн даргын тушаалаар томилж, чөлөөлнө.” гэж,

“7.14.Ажлын алба нь газарт, газар нь хэлтэст хуваагдсан зохион байгуулалттай байна.” гэх заалтыг “7.11.Гүйцэтгэх зөвлөл нь газар, хэлтэст хуваагдсан зохион байгуулалттай байна.” гэж,

“7.15.Нам нь эмэгтэйчүүдийн, залуучуудын, ахмадын асуудал хариуцсан нэгжтэй байна.” гэх заалтыг “7.12.Нам нь гишүүдийн насны бүлэг, жендэрийн асуудал хариуцсан нэгжүүдтэй байж болно.” гэж тус тус өөрчилсөн,

“7.16.Намын ажлын алба нь намын Их хурал, намын Төлөөлөх зөвлөл, Удирдах зөвлөл, Хариуцлагын хороо, Маргаан хянан шийдвэрлэх зөвлөл, УИХ дахь намын бүлэгт чиг үүргээ хэрэгжүүлэхэд туслах үүрэгтэй.” гэх заалтыг хүчингүйд тооцсон,

2.8.Наймдугаар бүлэгт оруулсан нэмэлт, өөрчлөлтийн талаар

Намын дүрмийн “8.1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль, УИХ-ын сонгууль болон орон нутгийн сонгуульд нэр дэвших гишүүн нь Удирдах зөвлөлөөс баталсан дотоод сонгуулийн журамд заасан шалгуурыг хангасан байна.” гэх заалтын “гишүүн нь” гэсний ард “намын” гэж нэмсэн,

“8.2.Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль, УИХ-ын сонгуульд нэр дэвшигчдийг Төлөөлөх зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ. Нэр дэвшигчдийг сонгуулийн хооронд бүртгүүлэх ажлыг Гүйцэтгэх зөвлөл зохион байгуулна.” гэх заалтыг “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль, УИХ-ын сонгуульд нэр дэвшигчдийг Төлөөлөх зөвлөлийн хурлаар хэлэлцэн батална. Нэр дэвшигчдийг Төлөөлөх зөвлөлийн хуралд Намын дарга санал оруулж батлуулах бөгөөд намын хүний нөөцийн бодлогын хүрээнд нэр дэвшигчдийг Ерөнхий нарийн бичгийн даргатай зөвшилцөж тодруулна.” гэж,

“8.3.Аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын гишүүнд нэр дэвшигчийг тухайн намын байгууллагын хорооны хурлаар хэлэлцэн шийдвэрлэж, сонгуулийн тойргийн хороонд бүртгүүлнэ.” гэх заалтыг “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд нэр дэвшигчийг тухайн намын байгууллагын тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэн батална. Нэр дэвшигчдийг сум,

дүүргийн намын хорооны дарга дээд шатны намын хорооны даргатай, нийслэл, аймгийн намын хорооны дарга намын Ерөнхий нарийн бичгийн даргатай тус тус зөвшилцөн тодруулж, холбогдох намын хорооны тэргүүлэгчдийн хуралд санал оруулан батлуулна.” гэж тус тус өөрчлөн шинэчилсэн,

“8.4.Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал, хорооны иргэдийн нийтийн хуралд нэр дэвшүүлэх асуудлыг сум, хорооны намын үүрийн хурлаар шийдвэрлэж сонгуулийн холбогдох байгууллагад бүртгүүлнэ.” гэх заалтыг хүчингүйд тооцсон,

2.9.Есдүгээр бүлэгт оруулсан нэмэлт, өөрчлөлтийн талаар

Намын дүрмийн “9.1.УИХ дахь намын бүлэг /Бүлэг/ нь УИХ-ын гишүүнээр сонгогдсон намын гишүүдээс бүрдэнэ.” гэх заалтыг “Монгол Улсын Их Хурал (УИХ) болон иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (ИТХ)-д сонгогдсон намын гишүүдээр Намын бүлгийг байгуулна.” гэж,

“9.2.Бүлэг нь намын Төлөөлөх зөвлөлөөс баталсан журмын дагуу үйл ажиллагаа явуулна.” гэх заалтыг “Бүлгийн гишүүд нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн хүрээнд намын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхийг зорьж ажиллах үүрэгтэй бөгөөд УИХ дахь намын бүлгийн даргыг Ерөнхий нарийн бичгийн дарга, нийслэл, аймгийн ИТХ дахь намын бүлгийн даргыг тухайн шатны намын хорооны дарга Ерөнхий нарийн бичгийн даргатай зөвшилцөж, Дүүргийн ИТХ дахь намын бүлгийн даргыг дүүргийн намын хорооны дарга нийслэлийн намын хорооны даргатай зөвшилцөж тус тус санал оруулж бүлгийн гишүүд сонгоно.” гэж тус тус өөрчлөн шинэчилсэн,

“9.3.Бүлэг нь УИХ-аас гаргах хууль, тогтоол, бусад шийдвэрт намын бодлого болон шийдвэрийг тусгах, тэдгээртэй холбогдсон асуудлаар намын нэгдсэн байр суурийг илэрхийлэх үүрэгтэй.” гэх заалтын “УИХ-аас” гэснийг хассан,

2.10.Аравдугаар бүлэгт нэмэлт, өөрчлөлт ороогүй,

2.11.Арваннэгдүгээр бүлэгт оруулсан нэмэлт, өөрчлөлтийн талаар

Намын дүрмийн “11.6.Хариуцлагын ерөнхий хороог 3 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр намын Их хурлаас, нийслэл, аймаг, дүүргийн Хариуцлагын хороог тус бүр 3 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр Удирдах зөвлөлөөс, сумын хариуцлагын төлөөлөгчийг аймгийн намын хорооны хурлаас, хорооны хариуцлагын төлөөлөгчийг дүүргийн намын хорооны хурлаас өөрсдийн бүрэн эрхийн хугацаанд сонгон байгуулна.” гэх заалтыг “Хариуцлагын ерөнхий хороог 3 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр намын Их хурлаас, нийслэл, аймаг, дүүргийн Хариуцлагын хороог тус бүр 3 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр Төлөөлөх зөвлөлөөс сумын хариуцлагын төлөөлөгчийг аймгийн намын хорооны тэргүүлэгчдийн хурлаас, хорооны хариуцлагын төлөөлөгчийг дүүргийн намын хорооны тэргүүлэгчдийн хурлаас өөрсдийн бүрэн эрхийн хугацаанд сонгон байгуулж болно. Тухайн шатны Хариуцлагын хороог байгуулаагүй, төлөөлөгчийг сонгоогүй бол харьяалах дээд шатны Хариуцлагын хороо нь энэхүү дүрэмд заагдсан намын Хариуцлагын хорооны чиг үүргийг хэрэгжүүлнэ.” гэж тус тус өөрчлөн найруулжээ.

Намын дүрэмд оруулсан дээрх нэмэлт, өөрчлөлтүүдийг шинжлэн судлахад, дүрмийн 1.5-д “Намын бүтэн нэр” ХҮН нам”, товчилсон нэр “ХҮН”, англи хэлээр “The HUN Party” байна.” гэж өөрчлөн найруулж, хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалтыг 2022 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр хийлгэснээс гадна ““Өнөөдөр” сонинд² “Намын оноосон нэрээ “ХҮН” болгон өөрчлөв” гэж зарласан

² 2022.05.05-ны өдөр. Пүрэв №089 (7391) В3 тал.

талаарх баримтуудыг өргөдөлд хавсаргасныг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 22.1.1-т заасан баримт бичгийн бүрдүүлбэр хангагдсан гэж үзнэ.

Түүнчлэн, ХҮН-ын 7 дугаар ээлжит бус Их хурлаар “Хөдөлмөрийн Үндэсний Нам” гэх бүтэн нэрээ “ХҮН нам” гэж өөрчилснийг улсын бүртгэлд бүртгэхэд уг нэр нь байгууллага, аж ахуйн нэгжийн нэртэй адил биш, мөн улс төрийн намын улсын бүртгэлд “ХҮН нам” гэсэн нэр байхгүй тул Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.3, Улс төрийн намын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлагад тус тус нийцсэн байна.

Улс төрийн намын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Намын дүрэм, мөрийн хөтөлбөр, тэдгээрт оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хууль, энэ хуультай нийцэж байгаа эсэхэд Улсын дээд шүүх хяналт тавина” гэж зааснаар өргөдөл гаргагчаас ирүүлсэн намын нэрийн өөрчлөлт, дүрмийн нэмэлт, өөрчлөлт, мөрийн хөтөлбөрийн шинэчилсэн найруулга нь Улс төрийн намын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1,6.2, 11, 12 дугаар зүйлүүдэд заасан шаардлагыг зөрчөөгүй, мөн хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1-т заасан улсын бүртгэлд бүртгэхээс татгалзах үндэслэл тогтоогдоогүй тул дээрх өөрчлөлтийг улсын бүртгэлийн мэдээлэлд бүртгэх боломжтой бөгөөд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.8.3-т заасныг үндэслэн тус намын мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн хүрээнд улсын бүртгэлийн гэрчилгээг дахин олгох нь зүйтэй гэж Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас дүгнэв.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1-т заасныг тус тус удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Улс төрийн намын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6, 8 дугаар зүйлийн 8.8, 8.8.3-т заасныг тус тус баримтлан Хөдөлмөрийн Үндэсний Нам (ХҮН)-ын 2022 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит бус 7 дугаар Их хурлын “Намын мөрийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” 06, “Намын дүрмийн нэмэлт, өөрчлөлт батлах тухай” 07 дугаар тогтоолоор баталсан намын дүрмийн нэмэлт, өөрчлөлт, мөрийн хөтөлбөрийн шинэчилсэн найруулга, дүрмийн өөрчлөлтөөр намын оноосон нэрийг “ХҮН нам” гэж өөрчилсөн өөрчлөлтийг тус тус улсын бүртгэлийн мэдээлэлд бүртгэж, намын мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн хүрээнд гэрчилгээг дахин олгосугай.

2.Өргөдөл гаргагчаас улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 150,000 /нэг зуун тавин мянга/ төгрөгийг улсын орлогод хэвээр үлдээсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

Х.БАТСҮРЭН